



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН 2019-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: БӨА-2021/02/ШТА-ГА

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ ОЛГОСОН БАЙНА.**

Баян-Өлгий аймаг 2021 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 цахим хуудас:
Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 цахим хуудас: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 89838414 Цахим
хуудас: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хуудас: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг.....	4
Графикийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	
ХАНГАГДСАН БАЙНА.	7
1.1. Мэргэжлийн боловсролыг сургалтын хөтөлбөрийн дагуу олгосон байна.....	7
1.1.1. Сургууль хөгжүүлэх хэтийн болон жилийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажиллажээ.	7
1.1.2. Мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.	8
1.2. Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, сургалтын орчин бүрдсэн байна.	9
1.2.1 Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна.	9
1.2.2. Сургалтын дадлагын байрны 75 хувь нь стандартын шаардлагыг хангасан байна....	10
1.3.Төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж, сэтгэл ханамжийн судалгаа хийж дүгнэсэн байна.....	13
1.3.1. Нийт төгсөгчдийн 47.5 хувь нь ажлын байраар хангагдсан байна.	13
1.3.2. Чанарын судалгаагаар төгсөгчдийн 63.0 хувь нь ажил олгогчийн шаардлагад нийцсэн байна.....	16
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ БАЙНА.	16
2.1. Үйл ажиллагааны төсвийг бодитой төлөвлөсөн байна.	16
2.1.1. Төсвийн төсөлд 2020 оны төсвийг өмнөх оноос 532.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөжээ.	16
2.1.2. Нийт батлагдсан төсөв өмнөх оноос 14.9 хувиар нэмэгдсэн байна.	17
2.2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	18
2.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.	18
2.2.2. Орон тооны хязгаарыг 27 орон тоогоор хэтрүүлэн ажилласан байна.....	19
2.2.3. 2019-2020 оны хичээлийн жилд 18 суралцагчид 22.0 сая төгрөгийн тэтгэлгийг хууль бус олгосон байна.....	19
2.2.4. Үйлдвэрлэлийн дадлага, хоолны зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	20
2.3.Төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна	22
2.3.1 Өмч хөрөнгийг зохих журмаар бүртгэж, зориулалтаар нь ашиглаж байна.	22
2.3.2 Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна.	23
Холбогдох байгууллагын санал:.....	24
Саналд өгсөн тайлбар:.....	25
ДҮГНЭЛТ: 26	
ЗӨВЛӨМЖ: 27	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ЧСС	Чадамжид суурилсан сургалт
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ДЗОУБ	Дэлхийн зөн Олон Улсын байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХҮДХЗ	Хичээл үйлдвэрлэл, дадлага хийх зардал
УЗХ	Удирдлагын зөвлөлийн хурал

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Багш нарын боловсролын зэрэг	8-9
Хүснэгт 2	Багш нарын багшлах эрхийн зэрэг	9
Хүснэгт 3	Онолын танхимын талбайн хэмжээ	10
Хүснэгт 4	Дадлагын байрны талбайн хэмжээ	10-11
Хүснэгт 5	Хичээлийн лабораторийн талбайн хэмжээ	11
Хүснэгт 6	Төсвийн төсөлд хүргүүлсэн саналын зардлын зүйл анги	15-16
Хүснэгт 7	Төсвийн нийт зардлын гүйцэтгэл	16
Хүснэгт 8	Үйлдвэрлэлийн дадлагын зардлын харьцуулсан судалгаа	18

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2018-2019 оны 2.5 жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдал	13
График 2	2019-2020 оны 2.5 жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдал	13
График 3	2018-2019 оны 1 жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдал	14
График 4	2019-2020 оны 1 жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдал	14

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 9 дүгээр зүйлийн 9.1-д тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019-2020 оны үйл ажиллагааг дараах чиглэлээр шалгаж, дүгнэлт гаргах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх. ➤ Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт үр ашигтай байгаа эсэх. ➤ Байгууллагын дотоодын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019-2020 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийг бүрэн хамруулж, ажлын тайлан болон санхүүгийн тайлан, баримт материалд үндэслэн, бодит байдлыг үндэслэн шалгав.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817:7-2020, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, баримт материалыг шалгах, давтан тооцоолох, харьцуулах, дүн шинжилгээ хийн аудитын хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Үүрийнтуяа, аудитор Ж.Назгүл нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хамтран гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХАНГАГДСАН БАЙНА

1.1. Мэргэжлийн боловсролыг сургалтын хөтөлбөрийн дагуу олгосон байна

1.1.1. Сургууль хөгжүүлэх хэтийн болон жилийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажиллажээ

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь сургууль хөгжүүлэх 2014-2020 оны стратеги төлөвлөгөө боловсруулж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажилласан байна. Стратеги төлөвлөгөөний зорилтуудыг 2014-2016, 2017-2020 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Үүнтэй уялдуулан сургуулийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох заалтуудаас тусгаж, жил бүрийн эцэст хэрэгжилтийг гарган сургуулийн Удирдлагын зөвлөлийн хурал, төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж ажилласан байна.

2019 онд сургалтын албаны менежер, хяналт шалгалт мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн нар хамтран сургуулийн хөгжлийн 2014-2020 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг хийж биелэлтийг гаргаж үзэхэд: Нийт 4 багц зорилтын хүрээнд 13 дэд бүлгээр 87 ажил үйлчилгээ төлөвлөгдсөнөөс 49 ажил хэрэгжиж, 38 ажил тасарч хөтөлбөрийн хэрэгжилт нийт дүнгээрээ 57 хувьтай гарсан байна.

Сургуулийн удирдах зөвлөлийн хурлаар биелэлтийг хэлэлцүүлэн Удирдах зөвлөлөөс гарсан зөвлөмж, шийдвэрийг үндэслэн 2021-2024 оны сургуулийн стратегийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах, дээрх хэрэгжээгүй ажлуудыг нэмж тусгахаар төлөвлөсөн байна.

МСҮТөв нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 2019 онд 90 хувьтай, 2020 онд 88.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.15-д “Тус хуулийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хяналтыг тавина” гэж заасан боловч 2019, 2020 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон дээд шатны байгууллагаас мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн тус төвд Хяналт шинжилгээ, мониторинг, чанарын баталгаажуулалт хариуцсан мэргэжилтний орон тоотой боловч 2019, 2020 онд байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажил хийгдээгүй байна.

Дээрх байдал нь мэргэжлийн боловсролын байгууллагын зорилго, зорилт, сургалтын үр дүн, ажлын байрны болон ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжил, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргаж чадаж байгаад тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

1.1.2. Мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн байна

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6541:2015 “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага” стандарт, ажил мэргэжлийн лавлах, гадаадын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн үндэсний жишиг хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг үндэслэн 2017 оноос хойш Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллүүлж эхэлсэн ба 2.5 жилийн мэргэжлийн боловсрол олгох 1-р ангийг 2017-2018 оны хичээлийн жилд, 2018-2019 оны хичээлийн жилд 2-р ангийг, 2019-2020 оны хичээлийн жилд 3-р ангийг тус тус Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулж, бүх мэргэжлүүд уг хөтөлбөрт шилжсэн байна.

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, батлагдсан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн болон мэргэшүүлэх чадамжийн нэгжүүд (чадамжийн элемент, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт)-ийн агуулгыг бүрэн эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажилтан бэлтгэх, сургалтын агуулга, арга зүйг сайжруулах, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, багшийг хөгжүүлж, заах арга, мэргэжлийн ур чадварыг сайжруулах арга хэрэгсэл болгон уян хатан байдлаар хэрэгжүүлэх ажлыг дэс дараатай зохион байгуулж, үр дүнг тооцох бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна.

ХНХЯ-ны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 2.5 жилийн сургалттай ангид 14, 1 жилийн сургалттай ангид 23 мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 7 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл олгосон байна.

Аймгийн мэргэжлийн салбар зөвлөлөөс ХНХЯ-нд 2018-2019 оны хичээлийн жилд 1 жилийн сургалттай ангид 306, 2.5 жилийн сургалттай ангид 174, бүгд 480 суралцагч, 2019-2020 оны хичээлийн жилд 1 жилийн сургалттай ангид 302, 2.5 жилийн сургалттай ангид 208, бүгд 510 суралцагчийн элсэлт авах санал хүргүүлсэн байна.

Дээрх саналын дагуу ХНХЯ-ны сайдын 2018 оны А/129 дүгээр тушаалаар 480 суралцагч, 2019 оны А/196 тоот тушаалаар 510 суралцагчаар элсэлтийн хяналтын тоог баталж ирүүлсэн байна.

2018-2019 оны хичээлийн жилд 2.5 жилийн сургалттай ангид 12 мэргэжлээр, 1 жилийн сургалттай ангид 14 мэргэжлээр, 2019-2020 оны хичээлийн жилд 2.5 жилийн сургалттай ангид 8 мэргэжлээр, 1 жилийн сургалттай ангид 15 мэргэжлээр элсэлт авч сургалт явуулсан байна.

Тусгай зөвшөөрлөөр олгогдсон зарим мэргэжлийн ангиуд нь хичээлийн болон дадлагын байрны хүрэлцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнээс үүдэж сургалт явуулаагүй байна.

Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг сургууль өөрсдөө боловсруулан баталж мөрдөхөөр журамласны дагуу мэргэжлийн багууд хөтөлбөрөө хамтран боловсруулах жил бүр сайжруулалт хийж сургалтад ашиглаж ирсэн байна.

Эдгээрээс 2017 онд 4 хөтөлбөр, 2020 онд 9 хөтөлбөрийг Бүсийн арга Зүйн төвөөр хянуулж дүгнэлт гаргуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сүүлийн 3-4 жилийн сургалтын үйл ажиллагаанд дээд шатны болон хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй байгаа тул чанартай боловсрол олгож байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

1.2. Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, сургалтын орчин бүрдсэн байна

1.2.1 Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 дүгээр тушаалаар тус МСҮТ-ийн орон тооны хязгаарыг 93 орон тоогоор баталжээ. Үүнээс 55 багшийн орон тоо батлагдсанаас 2018-2019 онд 67 багш, 2019-2020 онд 74 багш ажилласан байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1-т “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна” гэж заасан бөгөөд багш нарын боловсролын зэргийг хүснэгтээр харуулбал:

Багш нарын боловсролын зэргийн судалгаа

Хүснэгт №01

№	Хичээлийн жил	Багш	Нийт багшийн тоо	Боловсролын зэрэг			
				Тусгай дунд	Дипломын	Бакалавр	Магистр
1	2018-2019	Ерөнхий эрдмийн танхим	22			10	12
2		Мэргэжлийн тэнхим	45		1	40	4
1	2019-2020	Ерөнхий эрдмийн танхим	24			12	12
2		Мэргэжлийн тэнхим	50		4	41	5

Эх сурвалж: МСҮТ-ийн хүний нөөцийн судалгаа

Дээрх хүснэгтээс харахад 2018-2019 оны хичээлийн жилд нийт мэргэжлийн багшийн 98.5 хувь буюу 50 багш бакалавр түүнээс дээш зэрэгтэй үүний 32% нь магистр зэрэгтэй байна. 2019-2020 оны хичээлийн жилд нийт мэргэжлийн багшийн 71.6 хувь буюу 53 багш бакалавр түүнээс дээш зэрэгтэй үүний 32% нь магистр зэрэгтэй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.2-т “Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна” гэж заасан бөгөөд багш нарын боловсролын зэргийг хүснэгтээр харуулбал:

Багш нарын багшлах эрхийн зэргийн судалгаа

Хүснэгт №02

№	Багш	Боловсролын зэрэг
---	------	-------------------

	Хичээлийн жил		Нийт багш ийн тоо	Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш	Мастер тогооч	Өндөр зэрэгтэй багш
1	2018-2019	Ерөнхий эрдмийн танхим	22	10	2			1
2		Мэргэжлийн тэнхим	45	16	8			11
1	2019-2020	Ерөнхий эрдмийн танхим	24	13	0			1
2		Мэргэжлийн тэнхим	50	22	6			11

Эх сурвалж: МСҮТ-ийн хүний нөөцийн ажилтнаас

Тогоочийн 1 дүгээр зэрэгтэй 5 багш, мужааны 4 дүгээр зэрэгтэй 1 багш, оёдлын 4 дүгээр зэрэгтэй 1 багш, үсчний 1 дүгээр зэрэгтэй 2 багш, цахилгаан-гагнуурын 5 дугаар зэрэгтэй 1 багш, сантехникийн 6 дугаар зэрэгтэй 1 багш байна.

Хуулийн 18.3-т “Багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш нь сургалтын заах арга зүй эзэмшиж, багшлах эрхийн үнэмлэх авсан байна” гэж заасан бөгөөд тус төвд шинээр ажилд орсон 5 багш багшлах эрх аваагүй байгаа нь энэ заалттай нийцэхгүй байна.

Тус 5 багшийг 2020-2021 хичээлийн жилд багшлах эрхийн сургалтад хамруулахаар Баруун бүсийн албанд саналаа хүргүүлж бүртгүүлсэн боловч цар тахлын улмаас сургалтад хамрагдаагүй байна.

1.2.2. Сургалтын дадлагын байрны 75 хувь нь стандартын шаардлагыг хангасан байна

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, номын сан, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна” гэж заасан.

Баян-Өлгий аймаг дахь МСҮТ нь хичээлийн 1 байртай, гуанзны 1 байр, дадлагын 7 байртай, биеийн тамирын 1 байртай, дотуур байрны 1 байртай байна. Хичээлийн байранд номын сан, спорт зал болон 2 лабораторитой, дотуур байранд 4 дадлагын өрөөтэй байгаа нь дээрх шаардлагыг хангажээ.

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6541:2015 "Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага, стандарт"-ын 10.5-ын “А”-д “Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ногдох хэмжээ 2м.кв-аас багагүй байна” гэж заасан байна.

Онолын танхимын талбайн хэмжээ

Хүснэгт №03

№	Өрөөний дугаар	Талбайн хэмжээ /метр.кв/	Хүүхдийн багтаамжийн тоо	Нэг удаагийн сургалтын багтаамж /хүүхдийн тоо/	
				2018-2019	2019-2020
1	104	20	15	15	15

2	105	48	30	20	20
3	106	48	30	18	20
4	107	20	15	16	16
5	109	48	30	20	18
6	110	48	30	30	30
7	204	48	30	18	16
8	205	48	30	30	30
9	206	48	30	15	15
10	207	48	30	15	15
11	208	48	30	15	15
12	211	25	20	15	15
13	Өрг-2	25	15	15	15
14	Өрг-3	40	30	15	15
15	ДБ- 1	35	20	16	20
16	ДБ- 2	40	20	18	20
17	ДБ- 3	40	20	16	20
Нийт		780 м2	425	307	315
Нийт онолын танхимд суралцагчийн тоо					
Нэг суралцагчид ногдох талбай				2.54 м2	2.47 м2

Эх сурвалж: МСҮТ-ийн сургалтын албанаас

Дээрх хүснэгтээс үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд нэг суралцагчид ногдох талбайн хэмжээ 2.54 метр квадрат, 2019-2020 онд 2.47 метр квадрат байгаа нь стандартын 10.5-ын “А”-д заасныг хангасан байна.

MNS 6541:2015 стандартын 10.5-ын “Б”-д “Дадлагын газрын талбайн хэмжээ тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах техник, тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааран 40м.кв-аас доошгүй бөгөөд тоног төхөөрөмж хоорондын зай нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах ба том оврын техник, тоног төхөөрөмж шаардагдах дадлагын газрын талбайн хэмжээ 110 м.кв-аас доошгүй байна” гэж заасан.

Дадлагын байрны талбайн хэмжээ:

Хүснэгт №04

№	Дадлагын байрны нэр	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)
1	Талх нарийн боов	15	52.5
2	Сантехник	15	180
3	Барилгын өргөн мэргэжил	15	76.7
4	Засал чимэглэл	15	88
5	Оёдол-эсгүүрийн №1	15	35.6
6	Оёдолын цех	15	86.5
7	Оёдол-эсгүүрийн №2	15	35
8	Авто засвар	15	96
9	Гагнуурчин	15	180
10	Үсчин	15	56.5
11	Гоо сайхан	15	52.5
12	Тогооч бармен	15	52.5

13	Тогооч нийтийн хоол	15	90
14	Цахилгаан	15	86.5
15	Барилгын мужаан	15	180
16	Симмулятор	15	16
	Нийт	240	1364.3

Эх сурвалж: МСҮТ-ийн сургалтын албанаас

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 16 дадлагын байртай бөгөөд 3 дадлагын байраас бусад нь стандартын шаардлагын хангасан байна.



Гагнуурчны ангийн дадлагын байр



Оёдлын ангийн дадлагын байр

Стандартын 10.5-ын “В”-д “Сургалтад зориулсан лабораторийн талбайн хэмжээ нь тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн овор хэмжээнээс хамааран 40 метр кв-аас доошгүй байх бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна” гэж заасан байна.

Хичээлийн лабораторийн талбайн хэмжээ

Хүснэгт №05

№	Танхимын нэр	Өрөөний №	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /М2/
1	Компьютерийн лаб. №1	өрг-№1	15	48
2	Компьютерийн лаб. №4	өрг-№2	15	20
	Нийт		30	68 м2

Эх сурвалж: МСҮТ-ийн сургалтын албанаас


Дээрх хүснэгтээс харахад лабораторийн 2 өрөөнөөс нэг нь стандартын шаардлагыг хангаагүй байна. Үүнд: Газар тариалангийн чиглэлийн дадлагын газар шаардлага хангаж чадахгүй байгаа ба гоо засалч мэргэжлийн сургалтыг туршилтаар анхны жилдээ явуулсан боловч бүрэн тохижуулж чадаагүй байна.

Дадлагын байрны тоног төхөөрөмжийн хүрэлцээг тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо ширхэг, суралцагчийн нэг төхөөрөмж дээрх хугацаа, суралцагчийн тоо зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцоход барилга, гагнуур, тогооч, оёдолчин зэрэг мэргэжлийн ангиудад хүрэлцээтэй байна. Оёдол, гагнуур, тогооч зэрэг зарим дадлагын байр сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан зэрэг нь

сургалт явуулах давуу тал болсон байна. Харин мужааны анги болон сантехникийн ангийн гар багаж хэрэгсэл нь хуучирч, элэгдсэн байна.



Мужааны ангийн дадлагын байр



Сантехникийн ангийн дадлагын байр

Дадлагын газрууд стандартын шаардлагын 75%-ийг хангаж, 2 ээлжээр, ээлж тус бүрдээ 15 суралцагч дадлага хийх боломжоор хангагджээ.

1.3.Төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж, сэтгэл ханамжийн судалгаа хийж дүгнэсэн байна

1.3.1. Нийт төгсөгчдийн 47.5 хувь нь ажлын байраар хангагдсан байна

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн" гэж заасан байна.

Засгийн газрын 2016 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 3-д орон нутагт үндэсний зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэх салбар зөвлөлтэй байна гэж заажээ.

Салбар зөвлөлийн дүрмийн 3 дахь хэсэгт орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг үнэн зөв, бодитоор тогтоох, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын мэргэжилтэй ажилтны захиалгыг судалж, шинээр элсүүлэх захиалгын саналыг мэргэжил бүрээр гарган мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хүргүүлж хамтран ажиллана гэж тусгасан байна.

Энэ тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2017 оны А/79 дугаар захирамжаар 9 гишүүний бүрэлдэхүүнтэй орон нутгийн салбар зөвлөлийг байгуулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тоон болон чанарын судалгаанд үндэслэн аймгийн салбар зөвлөлөөс тухайн оны хичээлийн жилийн элсэлтийн мэргэжил, суралцагчийн тооны саналыг ХНХЯамд хүргүүлдэг байна. МСҮТ-өөс 3 жилд нэг удаа хөдөлмөрийн зах зээлийн судалгаа авдаг бөгөөд 2017-

2020 онд аймгийн төвд тогтмол үйл ажиллагаагаа явуулдаг 60 аж ахуйн нэгжийг хамруулан судалгаа хийсэн байна.


Судалгаанд хамрагдсан 60 аж ахуйн нэгжийн 16 хувь нь барилгын, 39.9 хувь хоол үйлдвэрлэл, мэдээлэл технологи, аж үйлдвэрийн, 30 хувь нь тээвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын, 14.1 хувь нь газар тариалан, уул уурхайн байгууллага байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгаанд үндэслэн 2018-2019 оны хичээлийн жилд 1 жилийн сургалттай ангид 14 мэргэжлээр 276 суралцагч, 2.5 жилийн сургалттай ангид 12 мэргэжлээр 183 суралцагч, нийт 459 суралцагчийг, 2019-2020 оны хичээлийн жилд 1 жилийн сургалттай ангид 15 мэргэжлээр 294 суралцагч, 2.5 жилийн сургалттай ангид 8 мэргэжлийн 91 суралцагч, нийт 385 суралцагчийг тус тус элсүүлсэн байна. 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлт өмнөх оноос 15.9 хувиар буурсан нь цар тахлын хязгаарлалттай холбоотой байна.

Мэргэжлийн сургалтын буюу 1 жилийн сургалттай ангиас 2018-2019 оны хичээлийн жилд 249 суралцагч, 2019-2020 оны хичээлийн жилд 302 суралцагч төгссөн бол мэргэжлийн боловсролын буюу 2.5 жилийн сургалттай ангиас 2018-2019 оны хичээлийн жилд 180 суралцагч, 2019-2020 оны хичээлийн жилд 90 суралцагч тус тус төгссөн байна.

Төвийн нийгмийн түншлэл хариуцсан ажилтнууд хөдөлмөр эрхлэлтийн судалгааг төгсөгчидтэй утсаар холбогдож асуух байдлаар авч, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны мэргэжилтэн давхар түүврийн аргаар төгсөгчидтэй утсаар холбогдож баталгаажуулдаг байна.

2.5 жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдлыг графикаар харуулбал:




Эх сурвалж: нийгмийн түншлэл хариуцсан ажилтнуудаас

Тус төвийн нийгмийн түншлэл хариуцсан ажилтнуудын ирүүлсэн мэргэжлийн боловсролын анги буюу 2.5 жилийн сургалттай ангийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 2018-2019 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 55 хувь нь ажилгүй байна.

Нийт 180 төгсөгчөөс 3 хувь буюу 5 төгсөгч үргэлжлүүлэн сурч байгаа бөгөөд, 16 хувь буюу 29 төгсөгч мэргэжлээрээ, 23 хувь буюу 42 төгсөгч өөр мэргэжлээр, 3 хувь нь 6 төгсөгч гадаадад ажиллаж байгаа гэсэн судалгаа ирүүлжээ.

Харин 2019-2020 оны хичээлийн жилд нийт 90 төгсөгч төгссөнөөс 62 хувь ажилгүй байна. Судалгаанаас үзэхэд 20 хувь нь мэргэжлээрээ, 18 хувь нь өөр мэргэжлээр ажиллаж байгаа юм байна.

Нэг жилийн сургалттай ангийн ажлын байраар хангагдсан байдлыг графикаар харуулбал:



Эх сурвалж: нийгмийн түншлэл хариуцсан ажилтнуудаас

Мөн төвийн нийгмийн түншлэл хариуцсан ажилтнуудын ирүүлсэн мэргэжлийн сургалтын анги буюу нэг жилийн сургалттай ангийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 2018-2019 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 36 хувь нь ажилгүй байна. Нийт 249 төгсөгчөөс 7 хувь буюу 18 төгсөгч үргэлжлүүлэн сурч байгаа бөгөөд, 23 хувь буюу 56 төгсөгч мэргэжлээрээ, 31 хувь буюу 77 төгсөгч өөр мэргэжлээр, 3 хувь нь 8 төгсөгч гадаадад ажиллаж байгаа гэсэн судалгаа ирүүлсэн байна.

Харин 2019-2020 оны хичээлийн жилд нийт 302 төгсөгч төгссөн бөгөөд үүнээс 57 хувь ажилгүй байна. Судалгаагаар 18 хувь нь мэргэжлээрээ, 24 хувь нь өөр мэргэжлээр ажиллаж байгаа ба 1 хувь нь буюу 4 төгсөгч үргэлжлүүлэн сурч байгаа юм байна.

Ажил эрхлэлтийн байдлыг дүгнэж үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилийн мэргэжлийн боловсролын ангийн төгсөгчдөөс 45 хувь нь, мэргэжлийн сургалтын төгсөгчдөөс 64 хувь нь ажлын байраар хангагдсан бол 2019-2020 оны хичээлийн жилийн мэргэжлийн боловсролын ангийн төгсөгчдөөс 38 хувь нь, мэргэжлийн сургалтын төгсөгчдөөс 43 хувь нь ажлын байраар хангагдсан нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2020 онд гарсан цар тахалтай холбоотой ажлын байр хумигдсантай холбоотой байна.

Тус төвөөс 340 дүгээр Цэргийн анги, Дэлхийн зөн ОУБ, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 2018-2019 оны хичээлийн жилд 51, 2019-2020 оны хичээлийн жилд 96, нийт 147 суралцагчийг 5 мэргэжлээр зохион

байгуулсан түр сургалтад хамруулж ХНХЯ-наас “Чадамжийн гэрчилгээ” олгосон байна.

МСҮТөв нь нийгмийн түншлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн сургалт дадлагыг хамтран зохион байгуулах, төгсөгчдийг ажлын байраар хангах чиглэлээр 60 гаруй аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан байна.

1.3.2. Чанарын судалгаагаар төгсөгчдийн 63.0 хувь нь ажил олгогчийн шаардлагад нийцсэн байна.

Тус төвийн төгсөгчид нь ажил олгогчоос тавьж буй шаардлагыг бүрэн хангаж буй эсэхийг дүгнэхийн тулд 3 жилд нэг удаа сэтгэл ханамжийн судалгаа явуулж байгаа бөгөөд 2017-2020 онд 60 аж ахуйн нэгж байгууллагыг судалгаанд хамруулсан байна.

Судалгааг 5 чиглэлээр 26 асуултын дагуу явуулж чадвар, чадамж тус бүрээр үнэлсэн байна. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд судалгааны оролцсон ажил олгогчдын саналаар 38 ажил олгогч буюу 63.3 хувь тус төвийн төгсөгчид ажил олгогчоос тавьсан шаардлагад нийцдэг гэсэн бол 21.1 хувь нь “хувь хүнээс хамаардаг ба заримдаа нийцдэггүй” гэж хариулжээ. Үлдсэн ажил олгогчдын хувьд буюу 15.6 хувь “бидний шаардлагад нийцдэггүй” гэж хариулсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ БАЙНА

2.1. Үйл ажиллагааны төсвийг бодитой төлөвлөсөн байна

2.1.1. Төсвийн төсөлд 2020 оны төсвийг өмнөх оноос 532.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөжээ

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны үйл ажиллагааны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1555.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1555.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

2019 оны төсвийн төсөлд нийт зарлагын 1552.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төвийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2098.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2098.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2020 оны төсвийн төсөлд нийт зарлагын 2094.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Төсвийн төсөлд хүргүүлсэн саналыг зардлын зүйл ангиар нь харуулбал:

Хүснэгт №06

№	Зардлын зүйл анги	2019 он	2020 он
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	889.8	1,269.6
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111.2	171.4
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212.2	223.8
4	Хангамж бараа материалын зардал	16.0	16.0
5	Норматив зардал	88.3	88.3
6	Эд хогшил, урсгал засварын зардал	9.9	9.9
7	Томилолт, зочны зардал	5.8	5.8
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4.1	4.1
9	Бараа үйлчилгээний бусад зардал	84.2	79.2
10	Бусад урсгал шилжүүлэг	144.9	230.3
	Нийт төсөв	1,566.4	2,098.4

Эх сурвалж: МСҮТ-ийн 2019, 2020 оны төсвийн төсөл

2020 оны төсвийн төсөлд цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэх төсвийг 2019 оноос нэмэгдүүлж хүргүүлсэн байна.

Орон тоог 2019, 2020 оны төсвийн төсөлд удирдах ажилтан 2, гүйцэтгэх ажилтан 77, үйлчлэх ажилтан 14, нийт 93 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2.1.2. Нийт батлагдсан төсөв өмнөх оноос 14.9 хувиар нэмэгдсэн байна

МСҮТ-ийн 2019 оны үйл ажиллагаанд 1808.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, 1805.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 3.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Харин 2020 оны үйл ажиллагаанд нийт 2078.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2075.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.0 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 1.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2019 онд 253.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2020 онд 19.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны батлагдсан төсөв өмнөх оноос 253.0 сая төгрөгөөр буюу 14.9 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлын батлагдсан төсөв өссөнтэй холбоотой байна.

2.2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна

2.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна

Гүйцэтгэлээр 2019 онд улсын төсвөөс 1790.0 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 1793.5 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1793.5 сая төгрөгийг зарцуулжээ.

2020 онд улсын төсвөөс 2065.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 2.3 сая төгрөгийн орлого оруулж, нийт 2067.9 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2067.9 сая төгрөгийг зарцуулсан байна. 2019 онд 15.2 сая төгрөгийг, 2020 онд 10.8 төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа:

Хүснэгт №07

Зардлын нэр	2019 он		Зөрүү	Эзлэх хувь	2020 он		Зөрүү	Эзлэх хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	1,808.5	1,793.2	15.3	99.2	2,078.6	2,067.9	10.7	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,141.7	1,141.7	-	100.0	1,359.0	1,358.9	0.1	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147.8	147.8	-	100.0	183.2	183.2	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195.7	195.7	-	100.0	208.5	205.7	2.8	98.7
Хангамж, бараа материалын зардал	16.0	16.0	-	100.0	25.2	22.7	2.5	90.1
Нормативт зардал	63.3	52.5	10.8	82.9	34.0	29.8	4.2	87.6
Эд хогшил, урсгал засварын зардал	24.9	24.9	-	100.0	12.1	12.1	-	100.0
Томилолт, зочны зардал	5.8	5.8	-	100.0	0.1	0.1	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7.1	7.0	0.1	98.6	4.3	3.8	0.5	88.4
Бараа үйлчилгээний бусад зардал	79.2	79.2	-	100.0	54.8	54.2	0.6	98.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127.0	122.6	4.4	96.5	197.4	197.4	-	100.0

Эх сурвалж: МСҮТ-ийн 2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн зарлагын гүйцэтгэл 2019 онд 1793.5 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь нормативт зардлыг 10.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 4.4 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсантай холбоотой.

2020 онд төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 2067.9 сая төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой зардлыг 2.8 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2.5 сая төгрөгөөр, нормативт зардлыг 4.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2019 онд 26.5 сая төгрөгийн санхүүжилт, 2020 онд 20.8 сая төгрөгийн орлого хүлээн авч зориулалтын дагуу зарцуулжээ.

МСҮТ-ийн 2019, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2.2.2. Орон тооны хязгаарыг 27 орон тоогоор хэтрүүлэн ажилласан байна

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын тушаалаар ажиллагсдын цалинг ажиллагсдын жил, зэрэглэл, мэргэжлийн зэрэг, ур чадвар, кабинет, удаан жил, мэргэшлийн зэрэг, унаа хоолны хөнгөлөлтийг ХНХЯ-ны сайдын үлгэрчилсэн загвартай уялдуулан 2019, 2020 оны 1 дүгээр сарын А/01 тоот тушаалуудаар шинэчлэн тогтоосон байна.

Цалин хөлсийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол, 2019 оны 472 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

МСҮТ-ийн 2019 оны цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 1141.7 сая төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 147.8 сая төгрөгийн, 2020 оны цалин, нэмэгдэл урамшуулалд 1358.9 сая төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 183.2 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 2019 онд цалингийн зардалд 1141.7 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 147.8 сая төгрөг, 2020 онд цалингийн зардалд 1358.9 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 183.2 сая төгрөгийг тус тус зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төвийн 2019, 2020 оны батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 93 хүнээр баталсан боловч гүйцэтгэлээр 120 орон тоогоор ажиллаж, орон тооны хязгаарыг 27 хүнээр хэтрүүлэн ажилласан байна.

2019 онд улирлын ажлын үр дүнгээр олгох урамшуулалд 88.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 52.7 сая төгрөгийн урамшуулал, хоолны зардлын төсөвт 56.4 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 45.4 сая төгрөгийн хоолны зардалд олгож, зөрүү 46,9 сая төгрөгийг илүү орон тооны цалингийн зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

Мөн 2020 онд улирлын ажлын үр дүнгээр олгох урамшуулалд 88.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 70.8 сая төгрөгийн урамшуулал, хоолны зардлын төсөвт 56.4 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 46.7 сая төгрөгийг хоолны зардалд олгож, зөрүү 74.4 сая төгрөгийг илүү орон тооны цалингийн зардалд шилжүүлэн зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн тул аудитын дүнгээр зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.2.3. 2019-2020 оны хичээлийн жилд 18 суралцагчид 22.0 сая төгрөгийн тэтгэлгийг хууль бус олгосон байна

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасны дагуу суралцагчид олгох тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ” гэж Засгийн газрын 2015 оны 477, 2019 оны 12

дугаар тогтоолоор баталсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журамд заасан байна.

Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын үнэлгээ, ирцийн мэдээллийг мэргэжлийн боловсрол, сургалтын нэгдсэн цахим системд бүртгэсний дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас суралцагчийн тэтгэлгийн мөнгийг суралцагчийн банкин дахь харилцах дансанд шилжүүлдэг журамтай.

Тус төвийн захирлын 2019-2020 оны хичээлийн жилийн суралцагч элсүүлэх, суралцагчийн нэрсийн жагсаалт баталсан 2019 оны А/45 дугаар тушаалыг, төгсөгчдийн нэрсийг баталсан 2020 оны А/22 дугаар тушаалыг, бүх багш нарын ангийн журналыг www.mergetil.mn мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй тэтгэлэг олгосон суралцагчийн жагсаалттай нэг бүрчлэн тулгалт хийж шалгахад тухайн хичээлийн жилийн ангийн багшийн журналд бүртгэгдээгүй, хичээлд суугаагүй, ирцийн бүртгэл хийгдээгүй боловч цахим бүртгэлийн санд бүртгэгдсэн 18 суралцагчид 22.0 сая төгрөгийн тэтгэлгийг хууль бус олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”, Засгийн газрын 2020 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн тул хууль бус олгосон тэтгэлгийг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мэдээллийн нэгдсэн системийг шинэчилсэнтэй холбоотой 2018-2019 оны хичээлийн жилийн тэтгэлэг авсан суралцагчийн мэдээллийг аудитын хугацаанд ирүүлээгүй тул шалгах боломжгүй болсон. Мөн 2018-2019 оны хичээлийн жилийн суралцагч элсүүлэх, суралцагчийн нэрсийн жагсаалт батлах А/101 дугаар тушаалын хавсралт, 2019 оны Төгсөгчдийн нэрс батлах тухай А/03 тушаалын хавсралт, 2019-2020 оны хичээлийн жилийн тушаалын хавсралтыг буруу гаргаж хавсаргасан, 2018-2019 оны хичээлийн жилийн гагнуурчин, 2019-2020 оны хичээлийн жилийн автомашин засварчин /1В-2/ ангийн багшийн журналыг ирүүлээгүй байгаа нь аудитыг хугацаандаа дуусгахад саад учруулсан тул аудитын явцад тус төвийн удирдлагад танилцуулж баримтжуулсан.

2.2.4. Үйлдвэрлэлийн дадлага, хоолны зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Хүснэгт №08

/сая төгрөгөөр/

Зардлын нэр	2018 он	2019 он	2020 он	Өсөлт, бууралт		Эзлэх хувь	
	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	2020-2018	2020-2019	2020-2018	2020-2019
Хичээл үйлдвэрлэл дадлагын зардал	84.2	79.2	54.8	(29.4)	(24.4)	34.9	30.8

Эх сурвалж: МСҮТ-ийн 2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус төвийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын батлагдсан төлөвлөгөөг сүүлийн гурван жилээр харьцуулж үзэхэд 2020 онд 2018 оноос 29.4 сая төгрөгөөр буюу 34.9 хувиар, 2019 оноос 24.4 сая төгрөгөөр буюу 30.8 хувиар буурсан байна. 2020 онд Ковид-19 цар тахал гарсантай холбоотой хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал буурсан байна.

Сургалт үйлдвэрлэлийн дадлагын байранд дадлагын хичээл явуулах багш, үйлдвэрлэлийн дадлагын хичээл явуулах сургалтын төлөвлөгөө, төсөл, материалын жагсаалт хийж, сургалтын албаны дарга, тэнхимийн эрхлэгч нараар батлуулж, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэх зарлагын падаантай хамт санхүүд өгч захирал, ерөнхий нягтлан бодогч нар хянаж худалдан авах материалын үнийг шилжүүлэн өгч байжээ.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын худалдан авах ажлыг жил бүр захирлын дэргэдэх үнэлгээний хороог 7 гишүүнтэй байгуулж 2019 оны А/08 тоот, 2020 оны А/04 тоот тушаалаар баталсан байна. Үнэлгээний хороо нь 2019 онд 4, 2020 онд 5 аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэх урилга хүргүүлж, харьцуулалтын аргаар буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн аж ахуй нэгжийг сонгон шалгаруулсан байна.

Үүнд: 2019 онд Асыл-Али, Банту, Назлы ХХК-иуд, 2020 онд Сауран, Назлы, Банту, Асыл-Али ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдтэй 1 жилээр гэрээ байгуулж ажилласан байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 20-25 хувийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал хүрэлцээгүйгээс 2019 онд 21.8 сая төгрөг, 2020 онд 16.3 сая төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

2019 оны батлагдсан төсөвт 57.5 сая төгрөг, 2020 оны батлагдсан төсөвт 25.1 сая төгрөгийн хоолны зардлын төсөв батлагдсан ба 2019 онд 46.8 сая төгрөгийг, 2020 онд 21.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хоолны зардлын худалдан авах ажлыг жил бүр захирлын дэргэдэх үнэлгээний хороог 7 гишүүнтэй байгуулж 2019 оны А/08 тоот, 2020 оны А/04 тоот тушаалаар баталсан байна. Үнэлгээний хороо нь 2019 онд 3, 2020 онд 3 аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэх урилга хүргүүлж, харьцуулалтын аргаар буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн аж ахуй нэгжийг сонгон шалгаруулсан байна.

2019, 2020 онд “Айсауле”, “Назлы”, “Ассу” ХХК-тай 1 жилийн хугацаагаар гэрээ байгуулж ажилласан байна.

2019 оны дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 2576 төгрөг зарцуулж, өдрийн нормыг 261 төгрөгөөр буюу жилийн дүнгээр 4.8 сая төгрөгийг, 2020 онд хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 3201 төгрөг зарцуулж, өдрийн нормыг 201 төгрөгөөр буюу жилийн дүнгээр 1.2 сая төгрөгийг төсвөөс тус тус илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” журмын холбогдох заалтыг зөрчсөн тул 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

2.3. Төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна

2.3.1 Өмч хөрөнгийг зохих журмаар бүртгэж, зориулалтаар нь ашиглаж байна

Тус төв нь 2019 онд 80.8 сая төгрөгийн, 2020 онд 17.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.Үүнд:

2019 оны эцэст Швед улсын иргэн Ф.Анитагаас 4 төрлийн хөрөнгө, бараа материалыг хандиваар хүлээн авсан байна. Үүнд: үндсэн хөрөнгөнд дотуур байранд угсардаг давхар ор 50 ширхгийг, 6 тасалгаатай нарийн шүүгээ 6, самбар 2 ширхгийг, бараа материалд 80 ширхэг орны матрасыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл тухайн валютын ханшаар үнэ тогтоож нийтдээ 1.2 сая төгрөгийн хөрөнгө авсан байна.

Мөн Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамнаас 55.3 сая төгрөгийн 26 ширхэг зөөврийн болон суурин компьютер, 2.5 сая төгрөгийн ном, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-аас элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 22.5 сая төгрөгийн балансын үнэтэй Mitsubishi L200 маркийн автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу балансаас балансад шилжүүлэн авч байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хөрөнгийн үнийг тогтоож 3.5 сая төгрөгөөр, Германы ГОУХАН /Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/-ийн төслөөр 5.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Сургуулийн аж ахуйн аргаар өөрсдөө барьсан 10.2 сая төгрөгийн Кузов засварын байр, суралцагчдын хийсэн бүтээл болох 2.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг орлогод тус тус авсан байна.

2020 онд Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамнаас 16.0 сая төгрөгийн 8 ширхэг зөөврийн компьютер, 1 принтер, 1 зурагт хүлээн авч, 0.4 сая төгрөгийн ном, суралцагчдын хийсэн бүтээл болох 1.1 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийг тус тус орлогод авсан байна.

Дээрх үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгүүд сургуулийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ба 2019 онд шилжүүлэн авсан 3.5 сая төгрөгийн өртөг бүхий автомашин эвдрэлтэй тул ашиглагдаагүй байна.

Төсвийн хөрөнгөөр 2020 онд 4.4 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авч данс бүртгэлд тусгажээ. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2019, 2020 онд томоохон хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

2019 онд 33.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 5.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 2020 онд 24.2 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл /4 ширхэг жолооны курсд ашиглаж байсан машин/, 17.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 7.9 сая төгрөгийн ном, нийтдээ 89.3 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны А-4/1601, 2020 оны 568, 569 тоот тогтоолууд, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж МСҮТ-ийн захирлын тоот тушаалаар акталж, данс бүртгэлээс хассан байна.

Үүнээс 24.2 сая төгрөгийн 4 автомашиныг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Авто засварын ангид хичээл практикийн материалаар ашиглуулахаар бараа материалын тайланд 2.4 сая төгрөгөөр үнэлж сэлбэг хэрэгсэл дансанд орлогод авсан байна.

2.3.2 Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн алба нь ерөнхий нягтлан бодогч 1, тооцооны нягтлан бодогч 1, нярав 2 гэсэн 4 орон тоогоор ажиллажээ. Ахлах нягтлан бодогч нь касс, харилцахын хуулгыг боловсруулж, ерөнхий дэвтэр хөтлөх, байгууллагын санхүүгийн тайлан гаргах, цалин хөлс, аж ахуй, санхүүгийн албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан байна.

МСҮТ-ийн захирлын 2019 оны А/20 дугаар тушаалаар өмч хөрөнгийг хамгаалах байнгын зөвлөлийг шинэчилж бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж, зөвлөлийг 8 гишүүнтэй томилсон байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн журам, төлөвлөгөө гарган ажиллаж, газрын эзэмшилд байгаа эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах болон шинээр эд хөрөнгө олж авахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төвийн захирлын 2019 оны А/32, А/56, 2020 оны А/28, А/43 дугаар тушаалуудаар батлагдсан эд хөрөнгийн тооллогын комисс үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулжээ.

Байгууллагад хөтлөгдвөл зохих анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг холбогдох журмын дагуу бүрэн хөтөлж, санхүүгийн баримт материалыг эмх, цэгцтэй үдэж, архивласан байна. Санхүүгийн баримт материалыг зохих журмын дагуу бүрдүүлж, баримт материалыг эмх, цэгцтэй архивласан тул аудитын явцад шалгахад хүндрэл гараагүй байна.

Холбогдох байгууллагын санал:

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

83120 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2212, E-mail: msut_bu@yahoo.com

2021.07.05 № 65

танай _____ -ны № _____ -т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Тус төвийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр
дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.
Ямар нэгэн тайлангийн төсөлд тусгах санал
байхгүй болно.

ЗАХИРАЛ  И.ЖАНБОЛАТ

Саналд өгсөн тайлбар:

Тайлангийн төсөлд ямар нэгэн санал ирүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Мэргэжлийн боловсролыг сургалтын хөтөлбөрийн дагуу олгосон байна.
2. Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.
3. Сургалтын дадлагын байрны 75 хувь нь стандартын шаардлагыг хангасан байна.
4. Нийт төгсөгчдийн 47.5 хувь нь ажлын байраар хангагдсан байна.
5. Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан боловч орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.
6. 2019-2020 оны хичээлийн жилд 22.0 сая төгрөгийн тэтгэлгийг хууль бус олгосон байна.
7. Төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэсэн зөвлөмж өгөгдөөгүй байна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/16

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж акт, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дарга /И.Жанболат/-д зөвлөсүгэй.

4. Аудитын акт, албан шаардлагыг статистик мэдээний бүртгэлд авч, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор /Б.Үүрийнтуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



D:\bichia herea\2021\tushaal.doc

Баян-Өлгий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын 02.01 оны
08 дугаар сарын 19-ны өдрийн
4/6 тоот тушаалын хавсралт
8317144071
БЮА0074 9007245

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн		Албан шаардлагын	
		Тоо	Мөнгөний дүн	Тоо	Мөнгөний дүн
1	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	1	22.0	1	74.4
		1	22.0	1	74.4